



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/92

Алтай хот

**“Аймгийн алдарт уяач тэмээчин” цол  
олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 86 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аймаг, сумдын уяач тэмээчин шалгаруулах журам”-ын 1, 3 дахь хэсэг, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 08 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:


1.Аймгийн хэмжээнд зохиогдсон тэмээний уралдаануудад үзүүлсэн амжилтаараа болзол хангасан Эрдэнэ сумын уяач Норовсамбуугийн Нямсүрэн, Цогт сумын уяач Лхүндэвийн Өөдөс, Шарга сумын уяач Түвшингийн Өсөхбаяр, Бигэр сумын уяач Чойнзонгийн Отгондэлэг нарт “Аймгийн алдарт уяач тэмээчин” цол олгож, зардлыг хавсралтаар баталсугай.

2.Зардалд шаардагдах 400,000 (дөрвөн зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 2013 оны  
10 дугаар сарын 10 ны өдрийн 1142 дугаар  
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Овог нэр	Сумын нэр	Мөнгөн дүн
1.	Н.Нямсүрэн	Эрдэнэ сум	100,000
2.	Л.Өөдөс	Цогт сум	100,000
3.	Т.Өсөхбаяр	Шарга сум	100,000
4.	Ч.Отгондэлэг	Бигэр сум	100,000
	Дүн		400,000

\_\_оОо\_\_